



“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,
206 тоот өрөө
Утас/факс: 7509-0044
Вэбсайт: www.dmp.mn

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-д шаардлагатай
шууд худалдан авалтын зар №140

Тендер шалгаруулалтын дугаар: ДААТҮТӨХК/20260603856

Төсөвт өртөг: 19,800,000 төгрөг

2026.06.03

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Нэгдсэн менежментийн тогтолцооны сайжруулалтын ажилд /Дижитал платформ программ / ашиглах	багц	1.0	Ажлын даалгаврын хамрах хүрээний дагуу

НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ САЙЖРУУЛАЛТЫН АЖИЛД / ДИЖИТАЛ ПЛАТФОРМ ПРОГРАММ / АШИГЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

1. Хамрах хүрээ: "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн бүтцийн нэгжүүд болон доорх стандартууд:

1.1 Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, 112 журмын нийцлийг үнэлэх.

1.2 Авлигын эсрэг менежментийн тогтолцооны MNS ISO 37001:2024 нийцлийг үнэлэх.

1.3 Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 нийцлийг үнэлэх.

1.4 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны MNS ISO 45001:2018 нийцлийг үнэлэх.

1.5 Байгаль орчны менежментийн тогтолцооны MNS ISO 14001:2016 нийцлийг үнэлэх.

1.6 Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага ISO/IES 17025:2017 нийцлийг үнэлэх.

2. Тавигдах шаардлага: Гүйцэтгэгч нь санал болгож буй дижитал платформ программ эзэмшигч байх бөгөөд мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байх.

3. Хийх ажил: Гүйцэтгэгч байгууллага нь тус байгууллагын үйл ажиллагаа, хамрах хүрээнд тохирсон цахим системийн суурь аксиомыг хэрэгжүүлэх чадвартай, тогтолцоог бүрдүүлэх замаар хэрэглэгчийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилготой дижитал платформ программ санал болгох дараах ажлуудыг хийж хэрэгжүүлнэ.

д/д	Гүйцэтгэх ажил	Тайлбар
1	Дижитал платформ программ ашиглах бэлтгэл ажлыг хангах	Платформд байгууллага хэрхэн SETUP хийх сургалт орох 1. Компанийн мэдээллийг бүрэн тохируулсан байна. 2. Үйл ажиллагаанд ашиглагддаг нэг алгоритмыг үүсгэсэн байна. 3. Нэг ажлын байрыг үүсгэсэн байна. 4. Үндсэн болон дэд функцүүдийг үүсгэсэн байна. 5. Бүртгэлтэй хэрэглэгч платформыг ашиглахад бэлэн болсон байна.

		<p>Платформд ажил хэрхэн төлөвлөж гүйцэтгэх хүрээнд сургалт орох</p> <ol style="list-style-type: none"> Газар/хэлтэс бүрд дор хаяж нэг ажил төлөвлөсөн байна. Газар/хэлтэс бүрийн дор хаяж нэг ажилтан төлөвлөсөн ажлуудыг 7 хоногийн төлөвлөгөөнд тусгасан байна. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг оруулж туршсан байна. Ажилтнуудыг чадавхжуулах ажлын байран дээрх сургалтыг 1-2 удаа зохион байгуулна. Сургалтыг зохион байгуулах зардал (байр, унаа, хоол)-ыг өөрсдийн зардлаар хариуцана. <p>Оролцогч талуудаа хэрхэн бүртгэх хүрээнд сургалт орох</p> <ol style="list-style-type: none"> Оролцогч талуудын үүсгэсэн байна. Оролцогч талуудад бүртгэх шаардлагатай мэдээллийг 1 оролцогч талд тохируулсан байна. Оролцогч талын бүртгэл хэсэгт дор хаяж 1 оролцогч тал бүртгэсэн байна. <p>Комплаинсийн шийдлүүдийг ашиглах хүрээнд сургалт орох</p> <ol style="list-style-type: none"> Компанийн дор хаяж нэг дүрэм, журмыг угсарсан байна. Компанийн дүрэм, журмаас ажил үүсгэсэн байна. Зөрүүний шинжилгээний нэг тайлан гаргасан байна.
2	Мэдээллийн нууцлал, хамгаалалтын бүрэн шийдсэн тохиргоотой байх	<ol style="list-style-type: none"> Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлыг хамгаалах болон бусад холбогдох хууль, тогтоомжид заасан үндэслэлийн дагуу хэрэглэгчийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж, хадгална. Хэрэглэгчийн хувийн мэдээлэл нь Хэрэглэгчийн нууц мэдээлэл болно. Талууд нууц мэдээллийг тухай бүр тохирсон арга, хэлбэрээр чандлан хамгаалах, задруулахгүй байх бүх арга хэмжээг авна. Нууцлалын бодлогыг нууцад хамаарахгүй мэдээллээс бусад Хэрэглэгчийн мэдээлэл нь Хэрэглэгчийн өгөгдөл болгон ашиглах боломжтой. Нууцлалын мэдээллийг захиалагч хянах боломжтой байх. Талууд оюуны өмчийг тухай бүр тохирсон арга, хэлбэрээр хамгаалах, задруулахгүй байх бүх арга хэмжээг авна. Админ удирдлагын системд зөвхөн зөвшөөрөгдсөн этгээд бүртгүүлж хандах боломжтой байх Эрхийн баталгаажуулалт хийгддэг байх /танилт нэвтрэлтийн “ДАН” систем, цахим шуудан гэх мэт/;
3	Дижитал платформ программ ашиглалт	<ol style="list-style-type: none"> Хэрэглэгчийг Программ ашиглах сургалтын материал, гарын авлага, зааварчилгаа бичлэгээр хангах; Программын ашиглалттай холбоотой Хэрэглэгчийн ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч тухай бүр шийдвэрлэх боломжтой алдаа, доголдол байвал шуурхай хариуцсан ажилтанд мэдэгдэж засварлуулах, алдаа ноцтой байх тохиолдолд системийн багт хүргүүлэн хэдий хугацаанд засагдах хугацааг тодорхой хэрэглэгчид мэдэгдэх; Платформ өдөр бүр 24 цаг программын хэвийн үйл ажиллагааг хангах; Техникийн өргөтгөл, Программын өөрчлөлт, шинэчлэлт хийхтэй холбоотой үйлчилгээнд түр хугацааны зогсолт хийх тохиолдолд Хэрэглэгчид и-мэйл хаяг болон бусад цахим хэрэгслээр дамжуулан 1 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх бөгөөд гэрээний хугацаа ашиглаагүй хугацаагаар сунгагдах; Хэрэглэгч хүсэлтээ ирүүлсэн тохиолдолд хэрэглэгчийн мэдээллийг CSV өргөтгөлөөр хуулж өгөх. Санал болгож буй платформ ашиглах үйлчилгээний бэлтгэл ажил дууссанаар платформын ашиглах үндсэн хугацаа эхэлнэ. Компанийн баримтжуулсан мэдээллийн чиг үүргийн давхцалыг арилгах нийцлийг үнэлэх.

		8. Зөрүүний шинжилгээ хийдэг байх. 9. Шинжилгээний тайланг оффлайн хэлбэрээр татаж авч, хэвлэж унших боломжтой байх 10. Санал болгож буй платформыг 31-ээс багагүй ажилтан ашиглах эрх дагалдах
4	Ажлын туршлага	1. Мэдээлэл технологийн салбарт 5 жил ажилласан туршлагатай 2. Санал болгож буй цахимжуулалтын платформ ижил төстэй ажил хэрэгжүүлж байсан туршлагатай. 3. Өмнө нь хууль, эрх зүйн баримт бичигт хиймэл оюун ухаан (NLP) ашиглан дүн шинжилгээ хийх, дүгнэлт боловсруулах чиглэлээр бодит ажил гүйцэтгэсэн туршлагатай байх. 4. Олон улсын зах зээлд мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлсэн, экспортолсон туршлагатай байх.
5	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	1. Чанарын удирдлагын тогтолцооны /ISO:9001/ стандартаар баталгаажсан байх. 2. Мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 хангасан байх 3. Төсөлд санал болгож буй шинжилгээний аргачлал, алгоритм эсвэл ашиглаж буй шийдлийн оюуны өмчийн эрхийг эзэмшдэг, эсвэл ашиглах онцгой эрхтэй болохыг нотлох (Зохиогчийн эрхийн гэрчилгээ эсвэл Патент). 4. Дэлхийн тэргүүлэх LLM (Large Language Model) хөгжүүлэгч эсвэл үйлчилгээ үзүүлэгч байгууллагын (Google, OpenAI, Microsoft, AWS г.м) албан ёсны түнш/хамтрагч байх, эсвэл Enterprise түвшний API ашиглах албан ёсны эрхтэй байх.
6	Гарах үр дүн	1. Хамрах хүрээний дагуу стандартуудын нийцлийг хиймэл оюун ухаанаар (AI) үнэлэх 2. Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, 112 журмын холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийж, сайжруулах ажлын саналыг хиймэл оюун ухаанаар боловсруулж өгөх 3. Авилгын эсрэг стандартын холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийж, сайжруулах ажлын саналыг хиймэл оюун ухаанаар боловсруулж өгөх 4. Нэгдсэн менежментийн тогтолцооны үйл явцын төлөвлөгөө, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, анализ хийх, дата сан үүсгэх 5. Нэгдсэн менежментийн тогтолцооны тушаал шийдвэрийг системээр дамжуулан цахимжуулах, дата сан үүсгэх 6. Нэгдсэн менежментийн тогтолцооны ажлын урсгалыг тогтоож, анализ хийх боломж бүрдсэн байх. 7. Нэгдсэн менежментийн тогтолцооны ажлын урсгалд өөрчлөлт ороход хэрэглэгч бие даан тохируулж, угсрах боломж бүрдсэн байх. 8. Нэгдсэн менежментийн тогтолцооны баримт бичгүүдийг хэрэглэгч тухай бүр цахимжуулах боломж бүрдсэн байх. 9. Гүйцэтгэгчээс санал болгосон дижитал платформ дээр ажиллах чадвартай 35 ажилтанг бэлтгэсэн байх.

Жич:

- Урьдчилгаа төлбөр олгохгүй
- Төлбөрийг ажил гүйцэтгэсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор төлнө.

Бүрдүүлж ирүүлэх материал:

- Албан бичиг /Үнийн санал, ажил гүйцэтгэх хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/
- Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ, Татварын өргүй тухай тодорхойлолт
- Ажлын даалгавар, танилцуулга, бусад нотлох баримт
- Хариуцах этгээдийн итгэмжлэл, холбогдох мэйл, утасны дугаар

**Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл**

Шууд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах хаяг:
Худалдан авалтын хэлтэс
/procurement@dmp.mn/
Утас: 7509-0044